



ЗАВХАН АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

САНХҮҮГИЙН АУДИТЫН ТАЙЛАН

Завхан аймгийн Төсвийн ерөнхийлөн захирагчийн 2020
оны төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн
аудит

Аудитын код: ЗАА-2021/01/СТА-ТЕЗ



Улиастай
2021 он

Дарга, тэргүүлэх аудитор Д.Бат-Ундраа

Утас: 70463612 Цахим хаяг: bat-undraad@audit.gov.mn

Аудитын менежер Г.Хашцэцэг

Утас: 70463783 Цахим хаяг: khashtsetsegg@audit.gov.mn

Аудитор Б.Жалбаа

Утас: 89330330 Цахим хаяг: jalbaab@audit.gov.mn

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг
дээрх хаягаар авна уу. www.audit.mn

Агуулга

Аудитын тайланг бэлтгэсэн:	Товчилсон үгийн тайлбар	2
Завхан аймаг дахь Төрийн аудитын газар	Хүснэгт, графикийн товъёог.....	3
Дарга, тэргүүлэх аудитор Д.Бат-Ундраа	Аудитын зорилт, хамарсан хүрээ, арга зүй, шалгуур үзүүлэлт	4
Аудитын менежер Г.Хашцэцэг	ЗОРИЛТ -1 Орон нутгийн орлогын төлөвлөлт гүйцэтгэл	
Аудитор Б.Жалбаа	ЗОРИЛТ 2. Орон нутгийн зарлагын төлөвлөлт, гүйцэтгэл	
	ЗОРИЛТ 3. Нэмэлт санхүүжилтийн орлого, зардал	
	ЗОРИЛТ 4. Авлага, өглөг.....	
2021 оны 04 дүгээр сарын 20-ны өдөр	Дүгнэлт	
	Зөвлөмж	
Уг тайланг ТАГ-ын Веб сайт-аас үзнэ үү. http://audit.mn	Холбогдох байгууллагаас ирүүлсэн санал.....	
	Аудитын тайланг баталгаажуулсан тушаал	

1. ТОВЧИЛСОН ҮГИЙН ТАЙЛБАР

СЯ	Сангийн яам
СЯХ	Сангийн яам хянасан
ТЕЗ	Төсвийн ерөнхийлөн захирагч
АИТХ	Аймгийн иргэдийн төлөөлөгчдийн хурал
ААНБ	Аж ахуй нэгж байгууллага
СИТХ	Сумын иргэдийн төлөөлөгчдийн хурал
ЗДТГ	Засаг даргын тамгын газар
ОНХС	Орон нутгийн хөгжлийн сан
СХС	Сум хөгжүүлэх сан
ОНӨААТҮГ	Орон нутгийн өмчит аж ахуйн тооцоот үйлдвэрийн газар

2. ХҮСНЭГТ, ГРАФИКИЙН ТОВЬЁОГ

№	Тайлбар	Хуудасны дугаар
Хүснэгт №1	Орон нутгийн суурь орлого болон улсын төсвийн орлогын шилжүүлэг /Сангийн яам хянасан/	6
Хүснэгт №2	Орон нутгийн суурь орлогын төлөвлөлт	7
Хүснэгт №3	2020 оны төсвийг санхүүжүүлэх эх үүсвэрийг	8
Хүснэгт №4	Төсвийн орлогын гүйцэтгэл	9
Хүснэгт №5	Төсөв хоорондын шилжүүлгийн гүйцэтгэл	11
Хүснэгт №6	Аймгийн суурь зарлагын төлөвлөлт	12
Хүснэгт №7	Орон нутгийн төсөвт байгууллагуудын зардлын төлөвлөгөө	13
Хүснэгт №8	Тусгай зориулалтын шилжүүлгийн байгууллагуудын зарлагын төлөвлөлт	15
Хүснэгт №9	Аймгийн ИТХ-аас баталсан тусгай шилжүүлгийн байгууллагуудын зарлагын төлөвлөгөө	15
Хүснэгт №10	Нийт зардлын гүйцэтгэл	16
Хүснэгт №11	Сумдад олгох санхүүгийн дэмжлэг	18
Хүснэгт №12	Нэмэлт санхүүжилтийн орлого	20
Хүснэгт №13	Авлагын үлдэгдэл	21
Хүснэгт №14	Богино хугацаат өр төлбөрийн үлдэгдэл	22
Графикийн товъёог		
№	Тайлбар	Хуудасны дугаар
График №1	Аймгийн ТЕЗ-ийн 2020 оны төсвийн нийт орлогын эх үүсвэр	7
График №2	Төсвийн орлогын бүтэц	8
График №3	Нийт зардлын бүтэц	16

3. Аудит хийх бүрэн эрх, үндэслэл

Аудитыг Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 9 дүгээр зүйлийн 9.1-д заасан бүрэн эрхийн хүрээнд Завхан аймгийн Төрийн аудитын газар хийж гүйцэтгэлээ.

Аудитын зорилт

“Завхан аймгийн Төсвийн ерөнхийлөн захирагчийн 2020 оны төсвийн гүйцэтгэл, үр дүн”-д аудит хийж, дүнг холбогдох байгууллага, албан тушаалтанд танилцуулахад аудитын зорилт чиглэгдлээ.

Хамарсан хүрээ

Орон нутгийн төсөв болон улсын төсвөөс санхүүжилт авсан, төсвийн орлого бүрдүүлдэг байгууллага, аж ахуй нэгж, орон нутгийн өмчийн оролцоотой хуулийн этгээдийн 2020 оны төсвийн гүйцэтгэлийн тайлан тэнцэл, судалгаа, мэдээлэл, бусад баримт материалд тулгуурлан аудитыг хийлээ.

Аудитын арга зүй

Аудитыг гүйцэтгэхэд Аудитын Дээд Байгууллагуудын олон улсын стандарт, Санхүүгийн аудитын журам, арга зүйг баримтлан холбогдох албан тушаалтнуудтай ярилцлага хийх, асуулга, лавлагаа авах, тайлан баримт материалд тулган баталгаажуулалт, дүн шинжилгээ хийх зэрэг арга зүйг ашиглахын зэрэгцээ аудитын судалгаа хөтөлбөр горимын дагуу нотлох зүйл цуглуулж, дүгнэлт, зөвлөмж боловсрууллаа.

Аудитад ашиглах хууль тогтоомж, шалгуур үзүүлэлт

Аудитад дараах хууль, эрх зүйн актыг шалгуур үзүүлэлт болгон ашиглана.

- Төрийн Аудитын тухай хууль
- Төсвийн тухай хууль
- Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хууль
- Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль
- Хөдөлмөрийн тухай хууль
- Татварын тухай хууль
- Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль
- ТБОНӨХБАҮХАТухай хууль
- Нийгмийн даатгалын тухай хууль
- Төрийн албаны тухай хууль
- Холбогдох бусад хууль, журам эрхийн акт

Аудит хийсэн хугацаа:

Аудитыг 2021 оны 04 дүгээр сарын 05-аас эхэлж 04 дүгээр сарын 20-нд дуусгав.

Аудит хийх багийн бүрэлдэхүүн

ЗАВХАН АЙМГИЙН ТЕЗ-ИЙН ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛД ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Аудитыг дарга, тэргүүлэх аудитор Д.Бат-Ундраа хянан удирдаж, үе шатны чанарын хяналтыг аудитын менежер Г.Хашцэцэг хэрэгжүүлж аудитор Б.Жалбаа гүйцэтгэв.

ЗОРИЛТ- 1. ОРОН НУТГИЙН ОРЛОГЫН ТӨЛӨВЛӨЛТ, ГҮЙЦЭТГЭЛ


Төсвийн орлогын төлөвлөлтийн талаар:

Сангийн яам Аймгийн ТЕЗ-ийн 2020 онд бүрдүүлэх орлогыг 79,955.1 сая төгрөгөөр анх баталсан бөгөөд улс орны эдийн засгийн хүндрэлтэй нөхцөл байдал, цар тахлын хөл хориотой холбоотой улсын хэмжээнд төсөвт тодотгол хийж төсвийн ерөнхийлөн захирагчийн бүрдүүлэх орлогыг 2,177.6 сая төгрөгөөр бууруулан 77,777.5 сая төгрөгөөр баталжээ.

Орон нутгийн суурь орлого болон улсын төсвийн орлогын шилжүүлэг
/Сангийн яам хянасан/

Хүснэгт-1 /сая.төг/

д/д	Орлогын нэр төрөл	Анх баталсан	Тодотгосон	Зөрүү	эзлэх хувь
1	Татварын орлого	7,631.0	7,455.0	176.0	9.6
2	Татварын бус орлого	493.6	523.6	-30.0	0.7
3	Санхүүгийн дэмжлэг	19,576.6	18,898.0	678.6	24.3
4	Тусгай зориулалтын шилжүүлэг	46,674.0	45,969.0	705.0	59.1
5	Эрүүл мэндийн даатгалын сангаас санхүүжих	423.6	423.6	0.0	0.5
6	Орон нутгийн хөгжлийн сан	5,156.3	4,508.3	648.0	5.8
	ДҮН	79,955.1	77,777.5	2,177.6	100.0



ЗАВХАН АЙМГИЙН ТЕЗ-ИЙН ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛД ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ


Аймгийн төсвийн орлогын суурь орлогын Сангийн яамны анх хянасан дүнг өмнөх оны төлөвлөгөөтэй харьцуулахад 736.3 сая төгрөгөөр нэмэгдүүлэн, өмнөх оны гүйцэтгэлтэй харьцуулахад 1,764.7 сая төгрөгөөр бууруулж баталсан байна. Харин тодотгосон дүнг өмнөх онтой харьцуулахад 590.3 сая төгрөгөөр нэмэгдүүлэн, өмнөх оны гүйцэтгэлтэй харьцуулахад 1,910.7 сая төгрөгөөр бууруулан баталжээ.

Хувь хүний орлогын буцаан олголтод 2020 онд 860.0 сая төгрөг олгохоор төлөвлөж татварын суурь орлогоос хасаж хянасан байна.

Орон нутгийн суурь орлогын төлөвлөлт

Суурь орлого	2019 он		Хүснэгт 2 /сая.төг/ Сангийн яам	
	Төлөвлөгөө	гүйцэтгэл	Анх хянасан	Тодотгосон
Татварын орлого	7,009.7	9,216.8	7,631.0	7,455.0
Татварын бус орлого	378.6	550.7	493.6	523.6
ДҮН	7,388.3	0.0	8,124.6	7,978.6

Сангийн яам төсөвт тодотгол хийхдээ суурь орлогыг 146.0 сая төгрөгөөр бууруулан баталжээ.



Аймгийн ИТХ-ын 2019 оны 49 дугаар тогтоолоор Сангийн яамны хянасан суурь орлогыг 160.0 сая төгрөгөөр нэмэгдүүлэн баталсан бөгөөд уг нэмэгдэл нь Аймгийн ИТХ-ын нэмэлт даалгавар байв. Мөн тусгай зориулалтын шилжүүлгийн байгууллагуудын өөрийн орлогоор 197.6 сая, төсөвт байгууллагуудын өөрийн орлогоор 85.5 сая төгрөгийн орлого бүрдүүлэхээр төлөвлөжээ.

Харин Аймгийн ИТХ-ын 2020 оны 61 дүгээр тогтоолоор төсөв тодотгохдоо Сангийн яамны тодотгосон дүнгээс 306.0 сая төгрөгөөр төсвийн орлогыг нэмэгдүүлэн баталжээ. Ингэхдээ Сангийн яамны хянасан суурь орлогын бууралт 146.0 сая төгрөгийг татварын орлогын давсан хэсгээс санхүүжүүлэхээр баталжээ.

Аймгийн ИТХ-ын 2020 оны 61 дүгээр тогтоолоор 2020 оны төсвийг санхүүжүүлэх эх үүсвэрийг дор дурдсанаар тодотгон баталжээ.

ЗАВХАН АЙМГИЙН ТЕЗ-ИЙН ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛД ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

д/д	Төсвийн эх үүсвэр	Мөнгөн дүн
1	Татварын болон татварын бус орлого	8,284.6
2	Аймгийн төсөвт улсын төсвөөс олгох санхүүгийн дэмжлэг	18,897.9
3	Аймгийн төсөвт улсын төсвөөс шилжүүлэх тусгай зориулалтын шилжүүлэг	45,969.0
4	Эрүүл мэндийн даатгалын сангаас санхүүжих	423.6
5	ОНХС-д олгох орлогын шилжүүлэг	4,508.3
6	Төсөвт байгууллагын өөрийн орлогоос	283.2
7	Урьд оны үлдэгдлээс санхүүжих	450.0
8	2020 оны татварын давсан хэсгээс санхүүжих	365.4
ДҮН		79,182.0

Төсвийн орлогын гүйцэтгэлийн талаар:

✓ Орон нутгийн татварын орлого 2020 онд 11,204.1 /татварын буцаан олголт 753.1 сая төгрөгийг хассан/ сая төгрөг төвлөрсөн нь батлагдсан төсвөөс 3,079.1 сая төгрөгөөр буюу 37.9 хувиар давж биелсэн байна.

Татварын орлогын гүйцэтгэлийг харуулбал дараах байдалтай байна.

Хүснэгт-4 /сая.төг/

д/д	Татварын нэр төрөл	Төлөвлөгөө /СЯХ/	Нэмэлт даалгавар /АИТХ/	Нийт төлөвлөгөө	Гүйцэтгэл	Биелэлт
1	Цалин, хөлс, шагнал, урамшуулал болон тэдгээртэй адилтгах хөдөлмөр эрхлэлтийн орлогын	5,480.0		5,480.0	6507.5	118.8
2	Үйл ажиллагааны орлого	87.0		87.0	67.4	77.5
3	Хөрөнгийн орлого /хадгаламжийн хүүгийн орлого/	900.0		900.0	1178.3	130.9
4	Шинжлэх ухаан, утга зохиол, урлагийн бүтээл туурвих, шинэ бүтээл, бүтээгдэхүүний болон ашигтай загвар	2.0		2.0		0.0
5	Шууд бус орлого /хувь хүнээс суутгасан суутгалын орлого/	200.0		200.0	930.5	465.3
6	Үл хөдлөх эд хөрөнгийн албан татвар	300.0		300.0	330.9	110.3
7	Бууны албан татвар	54.0		54.0	59.5	110.2
8	Авто тээврийн болон өөрөө явагч хэрэгслийн албан татвар	290.0		290.0	366.3	126.3
9	Улсын тэмдэгтийн хураамж	210.0		210.0	266.6	127.0
10	Түгээмэл тархацтай ашигт малтмал ашигласны төлбөр	12.0		12.0	26.2	218.3

ЗАВХАН АЙМГИЙН ТЕЗ-ИЙН ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛД ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

11	Хог хаягдлын үйлчилгээний хураамж	92.0		92.0	97.5	106.0
12	Газрын төлбөр	240.0	80.0	320.0	284.8	89.0
13	Ойн нөөц ашигласны төлбөр	180.0	20.0	200.0	323.4	161.7
14	Ан амьтны нөөц ашигласны төлбөр	5.0	30.0	35.0	5.8	16.6
15	Ус, рашааны нөөц ашигласны төлбөр	250.0	30.0	280.0	313.9	112.1
16	Байгалийн ургамлын нөөц ашигласны төлбөр	6.0		6.0	216.0	3,600.0
17	Бусад татвар	7.0		7.0		0.0
18	Зам ашигласны төлбөр			0.0	5.9	0.0
19	Газрын эрх борлуулсан			0.0	5.2	0.0
20	Үл хөдлөх эд хөрөнгө борлуулсан			0.0	114.1	0.0
	Татварын орлогын дүн	8,315.0	160.0	8,475.0	11,099.8	131.0
21	Торгуулийн орлого /татварын бус орлого/	480.0		480.0	848.1	176.7
22	Бусад орлого	30.0		30.0		0.0
23	татварын хүү торгуулийн орлого			0.0	9.3	0.0
	Татварын бус орлогын дүн	510.0	0.0	510.0	857.4	168.1
	Нийт татварын орлого	8,825.0	160.0	8,985.0	11,957.2	133.1
	Буцаан олголт	860.0		860.0	753.1	87.6
	Цэвэр дүн	7,965.0	160.0	8,125.0	11,204.1	137.9

Аймгийн ИТХ-аас 4 нэр төрлийн татварт нэмэлт орлого оруулах даалгавар өгснөөс ойн нөөц ашигласны төлбөр, ус рашааны нөөц ашигласны төлбөр зэрэг татварын төлөвлөгөө давж биелсэн байхад газрын төлбөр, ан амьтны нөөц ашигласны төлбөр биелээгүй байна. Ан амьтны нөөц ашигласны төлбөрийн хувьд ковид цар тахалтай холбоотой биелэгдээгүй, газрын төлбөрийн хувьд татварын барагдуулалтыг хангалтгүй гүйцэтгэсэн байна гэж үзлээ.

Тайланд онд 1 нэр төрлийн орлого тасарсан нь үйл ажиллагааны орлогын албан татвар байна. Энэ нь цар тахлын нөхцөл байдалтай уялдуулан Засгийн газраас ААНБ, жижиг дунд бизнес эрхлэгчдийн үйл ажиллагааны орлогыг албан татвараас чөлөөлсөнтэй холбоотой байна.

Бусад нэр төрлийн татварын орлогууд бүрэн биелсэн бөгөөд үүнээс өндөр дүнтэй давж биелсэн зарим татварыг авч үзвэл дараах байдалтай байна.

- I. Хөрөнгийн орлого буюу хадгаламжийн хүүгийн орлого 30.9 хувиар давсан нь жил бүр иргэдийн мөнгөн хадгаламж өсөлттэй байгааг харуулж байна.
- II. Хувь хүнээс суутгасан суутгалын орлого 365.3 хувиар давж биелсэн нь УИХ-ын болон орон нутгийн сонгууль болсонтой холбоотой сонгуулийн хороонд ажилласан албан хаагчдад мөнгөн урамшуулал олгосон,
- III. Авто тээврийн болон өөрөө явагч хэрэгслийн албан татвар 26.3 хувиар давсан байна. Энэхүү татвар нь жил бүр давж биелдэг байдлаас үзэхэд төлөвлөлт бодитой бус байна гэж үзлээ.

ЗАВХАН АЙМГИЙН ТЕЗ-ИЙН ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛД ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

- IV. Байгалийн ургамал ашигласны нөөц давж биелэхэд Улаанбаатар хот болон Сэлэнгэ аймгаас самар түүх зориулалтаар төлөвлөгөөнд тусгагдаагүй 200.0 сая төгрөгийг Их-Уул сумын төсөвт төвлөрүүлсэн нь нөлөөлжээ.

Орон нутгийн суурь орлогын төлөвлөгөөнд иргэний үл хөдлөх хөрөнгө борлуулсны орлогыг төлөвлөж өгөх шаардлагатай байна. Энэхүү нэр төрлийн татварын орлогоор жил бүр тогтмол орлого төвлөрчээ.

- ✓ Төсөвт байгууллагуудын өөрийн орлогоор нийт 296.8 сая төгрөгийн орлого бүрдүүлэхээр баталсны 283.2 сая төгрөгийг Аймгийн ИТХ-ын нэмэлт даалгавар байна. Гүйцэтгэлээр нийт 134.3 сая төгрөгийг төсөвт байгууллагын өөрийн орлогоор бүрдүүлсэн нь 162.5 сая төгрөг дутуу байна.
- ✓ Сум хөгжүүлэх сангийн зээлийн эргэн төлөлт, хүүгийн орлогоос 1,741.1 сая төгрөг төвлөрүүлэхээр төлөвлөж, гүйцэтгэлээр 1,422.9 сая төгрөгийн орлогыг бүрдүүлсэн байна.
- ✓ Улсын төсөв орон нутгийн төсөв хоорондын шилжүүлгээр нийт 69,375.2 сая төгрөгийн санхүүжилт батлагдсанаас гүйцэтгэлээр 69,143.7 сая төгрөгийн санхүүжилт олгогдсон нь 231.5 сая төгрөгийн санхүүжилт дутуу байна. Энэ нь ОНХС-ийн санхүүжилттэй холбоотой байна.

Төсөв хоорондын шилжүүлгийн гүйцэтгэл

Хүснэгт-5 /сая.төг/				
д/д	Төсвийн эх үүсвэр	Батлагдсан төсөв	Гүйцэтгэл	Зөрүү
2	Аймгийн төсөвт улсын төсвөөс олгох санхүүгийн дэмжлэг	18,897.9	18,897.9	0.0
3	Аймгийн төсөвт улсын төсвөөс шилжүүлэх тусгай зориулалтын шилжүүлэг	45,969.0	45,969.0	0.0
5	ОНХС-д олгох орлогын шилжүүлэг	4,508.3	4,276.8	231.5
ДҮН		69,375.2	69,143.7	231.5

- ✓ Эрүүл мэндийн даатгалын сангаас 423.6 сая төгрөгийн санхүүжилт батлагдсанаас 404.4 сая төгрөгийн санхүүжилт олгосон нь 19.2 сая төгрөг дутуу байна.

ЗОРИЛТ 2. ОРОН НУТГИЙН ЗАРДЛЫН ТӨЛӨВЛӨЛТ, ГҮЙЦЭТГЭЛ

Төсвийн зарлагын төлөвлөлтийн талаар:

Аймгийн ТЕЗ-ийн 2020 онд зарцуулах нийт зарлагын төслийг 92,873.6 сая төгрөгөөр тооцон сангийн яаманд хүргүүлсэн нь Сангийн яамнаас баталсан 2020 оны хязгаараас 33,756.2 сая төгрөгөөр илүү байв.

ТЕЗ-ийн 2020 оны нийт зарлагын төслийг 2019 оны гүйцэтгэлтэй харьцуулахад 31,660.5 сая төгрөг буюу 51.7 хувиар нэмэгдүүлсэн байна. ТЕЗ-ийн төсвийн төсөлд орон тоо нэмэгдүүлэх, тээвэр шатахуун, хоол хүнс, урсгал засвар, хөдөлмөр хамгааллын хэрэгсэл, дотоод албан томилолт, бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил, үйлчилгээний төлбөр, бараа үйлчилгээний бусад зардал, төрөөс иргэдэд олгох тэтгэвэр тэтгэмж зэрэг зардлуудыг нэмэгдүүлэхээр тооцоолжээ.

ЗАВХАН АЙМГИЙН ТЕЗ-ИЙН ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛД ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Зардлын төлөвлөлтийг салбараар нь авч үзвэл:

Орон нутгийн суурь зарлагын төслийг 31,477.1 сая төгрөгөөр тооцож хүргүүлсэн бөгөөд 2020 онд 2 удаа бууруулан баталжээ. Сангийн яам ТЕЗ-ийн санал хүргүүлсэн төслийг анх хянаад аймгийн суурь зарлагыг 3,499.6 сая төгрөгөөр, төсвийн тодотголоор 1,132.9 сая төгрөгөөр, нийт 4,632.5 сая төгрөгөөр бууруулж 26,844.6 сая төгрөгөөр баталжээ. Сангийн яам ТЕЗ-ийн төсвийн төслийг анх хянахдаа нэмэгдэл цалин хөлс, гэрээт ажилчдын цалин, гэрэл цахилгаан, түлш халаалт, замын сангийн хөрөнгийг нэмэгдүүлэн, тээвэр шатахуун, эд хогшил урсгал засвар, дотоод албан томилолт, бусдаар гүйцэтгүүлсэн ажил үйлчилгээний төлбөр, бараа үйлчилгээний бусад зардал, нийгмийн халамжийн тэтгэвэр тэтгэмж, нэг удаагийн тэтгэмж урамшууллын зардлуудыг бууруулан баталсан бөгөөд төсвийн тодотголоор мөн дээрх зардлуудыг бууруулан баталжээ.

Аймгийн суурь зарлагын төлөвлөлт

Хүснэгт-6 /сая.төг/

д/д	Зардлын төрөл	ТЕЗ-ийн санал	Анх хянасан /СЯ/	Тодотгосон /СЯ/
1	Аймгийн ИТХ	1,252.2	425.3	379.1
2	Сумын ИТХ	1,606.6	1,432.3	1,395.9
3	Аймгийн ЗДТГ	2,532.9	1,799.8	1,768.9
4	Сумын ЗДТГ	9,622.8	8,198.5	7,971.1
5	Хот тохижуулах газар	1,632.1	372.3	301.2
6	Ойн анги	127.5	105.2	101.6
7	Байгаль орчны газар	1,042.9	1,031.6	971.5
8	Аймгийн халамжийн сан	163.2	89.3	89.3
9	Санхүүгийн хяналт аудитын алба	194.7	143.1	135.6
10	Аймгийн засаг даргын ерөнхий данс	590.1	542.0	252.3
11	Орон нутгийн өмчийн газар	270.4	139.7	123.9
12	Хүүхдийн цэцэрлэг /тогтмол зардал	1,626.7	1,578.1	1,533.1
13	Ерөнхий боловсролын сургууль /тогтмол зардал/	4,991.5	5,432.3	5,253.7
14	Орон нутгийн хүүхдийн байгууллага /тогтмол зардал	62.8	66.6	64.3
15	газар зохион байгуулалт, геодиз, зураг зүйн газар /тогтмол зардал/	30.3	30.3	29.4
16	Эрүүл мэндийн төв /тогтмол зардал/	635.2	355.4	339.4
17	Орон нутгийн музей	386.9	311.5	307.5
18	Орон нутгийн номын сан	193.1	159.9	157.6
19	Аймгийн театр	1,303.5	1,101.1	1,087.0
20	Сумдын соёлын байгууллагууд	2,575.4	2,472.6	2,429.3
21	Биеийн тамир, спортын газар	341.3	1,034.8	997.1
22	Авто замын сан	295.0	1,155.8	1,155.8
	ДҮН	31,477.1	27,977.5	26,844.6

ЗАВХАН АЙМГИЙН ТЕЗ-ИЙН ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛД ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Аймгийн ИТХ-ын төсөв тодотгох тухай 2020 оны 61 дүгээр тогтоолд 2020 онд зарцуулах төсвийн зарлагыг 25,741.8 сая төгрөгөөр, сумын төсвөөс санхүүжүүлэх зардлыг 1,856.2 сая төгрөгөөр, нийт 27,598.9 сая төгрөгөөр баталсан нь Сангийн яамны баталсан төсвөөс 753.3 сая төгрөгөөр нэмэгдүүлэн баталжээ.

Орон нутгийн төсөвт байгууллагуудын зардлын төлөвлөгөө

Хүснэгт-7 /сая.төг/

д/д	Байгууллагын нэр	Анх баталсан		Тодотгосон	
		Сангий яам	АИТХ	Сангий яам	АИТХ
1	Аймгийн ИТХ	425.3	843.5	379.1	958.8
2	Сумын ИТХ	1,432.3	1,425.7	1,395.9	1,400.8
3	Аймгийн ЗДТГ	1,799.8	2,371.7	1,768.9	2,301.6
4	Сумын ЗДТГ	8,198.5	8,330.1	7,971.1	8,178.5
5	Хот тохижуулах газар	372.3	600.2	301.2	675.2
6	Ойн анги	105.2	135.3	101.6	134.8
7	Байгаль орчны газар	1,031.6	1,052.7	971.5	991.4
8	Аймгийн халамжийн сан	89.3	136.3	89.3	136.3
9	Санхүүгийн хяналт аудитын алба	143.1	188.3	135.6	188.3
10	Мал эмнэлэгийн үйлчилгээний хөлс	528.2	415.3	238.5	415.3
11	Ахмадын хороо		94.2		94.2
12	Хот нийтийн тээврийн хөнгөлөлт	13.8	13.8	13.8	24.8
13	Орон нутгийн өмчийн газар	139.7	205.8	123.9	170.8
14	Хүүхдийн цэцэрлэг /тогтмол зардал	1,578.1	1,224.2	1,533.1	1,173.4
15	Ерөнхий боловсролын сургууль /тогтмол зардал/	5,432.3	4,338.1	5,253.7	4,092.9
16	ГБХЗХГ /тогтмол зардал	66.6	66.6	64.3	66.6
17	ГХБХБГ /тогтмол зардал/	30.3	30.3	29.4	30.3
18	Эрүүл мэндийн төв /тогтмол зардал/	355.4	491.7	339.4	491.7
19	Орон нутгийн музей	311.5	303.2	307.5	303.3
20	Орон нутгийн номын сан	159.9	173.2	157.6	173.4
21	Аймгийн театр	1,101.1	907.4	1,087.0	902.0
22	Сумдын соёлын байгууллагууд	2,472.6	2,291.8	2,429.3	2,306.7
23	Биеийн тамир, спортын газар	1,034.8	1,135.9	997.1	1,129.1
24	Авто замын сан	1,155.8	1,377.6	1,155.8	1,257.6
ДҮН		27,977.5	28,152.9	26,844.6	27,597.9

Аймгийн ИТХ-аас төсөвт байгууллагуудын зарлагын төлөвлөгөөг батлахдаа байр ашиглалттай холбоотой тогтмол зардлаас 1,365.0 сая төгрөгийг гүйлгэн зарцуулахаар баталжээ. Энэ нь төсвийн хөрөнгө үрэлгэн, зориулалт бус зарцуулагдах эрсдэлийг бий болгож байгаа тул тогтмол зардлын хуваарилагдаагүй хэсгийг төсөвт

ЗАВХАН АЙМГИЙН ТЕЗ-ИЙН ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛД ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

байгууллагуудын зардлыг нөхөхөд зориулж хуваарилалгүй , төсөвт үлдээх чиглэл баримталж ажиллах нь зүйтэй байна.

Төсөвт байгууллагуудад санхүүжилт нэмж хуваарилсан нь Төсвийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 11.1.16 “төсвийн ерөнхийлөн захирагч, төсвийн байгууллага, бусад этгээдэд улсын төсвөөс санхүүжүүлэх хөтөлбөрийн санхүүжилтийг батлагдсан төсвийн дагуу олгох” гэсэн заалттай нийцэхгүй байна.

Өмнөх оны ТЕЗ-ийн төсвийн гүйцэтгэлд дүгнэлт өгөх аудитын тогтмол зардлаас бусад төсөвт байгууллагуудад нэмэлт төсөв хуваарилахгүй байх талаар тусгаж, чиглэл хүргүүлсэн боловч хэрэгжүүлж ажиллаагүй байна.

- Тусгай зориулалтын шилжүүлгийн байгууллагуудын 2020 оны зарлагын төслийг 61,396.4 сая төгрөгөөр тооцон сангийн яаманд хүргүүлсэн бөгөөд Сангийн яам анх хянахдаа 14,298.9 сая төгрөгөөр, төсвийн тодотголоор 704.9 сая төгрөгөөр, нийт 15,003.8 сая төгрөгөөр бууруулан баталжээ.

Тусгай зориулалтын шилжүүлгийн байгууллагуудын 2020 оны зарлагын төслийг Сангийн яам анх хянахдаа үндсэн цалин, үдийн цай, нэг удаагийн тэтгэмж урамшууллын зардлыг нэмэгдүүлж, нэмэгдэл цалин хөлс, хангамжийн бараа материал, хоол хүнс, хөдөлмөр хамгааллын хэрэгсэл, дотоод албан томилолт, бусдаар гүйцэтгүүлэх ажил үйлчилгээний төлбөр, хичээл үйлдвэрлэлийн дадлага, тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн тэтгэмж, хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад олгох тэтгэмж зэрэг зардлуудыг бууруулан баталжээ.

Харин төсвийн тодотголоор хүүхдийн цэцэрлэг, ерөнхий боловсролын сургуулийн төсөвт цалин хөлс, нийгмийн даатгалын шимтгэл зэрэг зардлыг нэмэгдүүлэн, хоол хүнс, бараа үйлчилгээний бусад зардал, хувийн хэвшлийн байгууллагад өгөх татаас, үдийн цай зэрэг зардлуудыг бууруулан баталж, бусад тусгай зориулалтын шилжүүлгийн байгууллагуудын төсөвт өөрчлөлт оруулаагүй байна.

Тусгай зориулалтын шилжүүлгийн байгууллагуудын зарлагын төлөвлөлт

Хүснэгт-8 /сая.төг/

д/д	Зардлын төрөл	ТЕЗ-ийн санал	Анх хянасан /СЯ/	Тодотгосон /СЯ/
1	Хүүхдийн цэцэрлэг	14,365.8	12,130.2	11,720.6
2	Ерөнхий боловсролын сургууль	38,998.6	26,789.4	26,494.0
3	Эрүүл мэндийн төв	6,318.2	6,559.7	6,559.7
4	ГХБХБГ	702.5	645.4	645.4
5	ГБХЗХГ	297.2	258.8	258.8
6	Өрхийн эмнэлэг	714.1	714.1	714.1
	ДҮН	61,396.4	47,097.6	46,392.6

Аймгийн ИТХ-ын төсвийн тодотгол батлах тухай 61 дүгээр тогтоолд тусгай зориулалтын шилжүүлгийн зарлагын төлөвлөгөөг Сангийн яамны баталсан дүнгээс 197.6 сая төгрөгөөр нэмэгдүүлэн баталсан нь тусгай зориулалтын шилжүүлгийн байгууллагуудын өөрийн орлого байна.

**Аймгийн ИТХ-аас баталсан тусгай шилжүүлгийн
байгууллагуудын зарлагын төлөвлөгөө**

Хүснэгт-9 /сая.төг/

д/д	Байгууллагын нэр	Анх баталсан		Тодотгосон	
		Сангий яам	АИТХ	Сангий яам	АИТХ
1	Хүүхдийн цэцэрлэг	12,130.2	12,137.9	11,720.6	11,728.2
2	Ерөнхий боловсролын сургууль	26,789.4	26,979.6	26,494.0	26,684.0
3	Эрүүл мэндийн төв	6,559.7	6,559.6	6,559.7	6,559.6
4	ГХБХБГ	645.4	645.4	645.4	645.5
5	ГБХЗХГ	258.8	258.8	258.8	258.8
6	Өрхийн эмнэлэг	714.1	714.1	714.1	714.1
	ДҮН	47,097.6	47,295.4	46,392.6	46,590.2

➤ Орон нутгийн хөгжлийн сангийн зарлагын төлөвлөгөөг Аймгийн ИТХ-ын 2020 оны төсвийн тодотгол баталсан 61 дүгээр тогтоолд аймгийн орон нутгийн хөгжлийн сангийн зарлагыг 3,500.3 сая төгрөгөөр баталсны 693.9 сая төгрөгийг өмнөх оны үлдэгдэл болон татварын давсан хэсгээс, 2,806.4 сая төгрөгийг орон нутгийн хөгжлийн санд олгох орлогоос санхүүжүүлэхээр баталжээ.

Харин сумд ОНХС-аас нийт 3,075.6 сая төгрөгийн зардал гаргахаар төлөвлөж, 1,493.5 сая төгрөгийг аймгийн орон нутгийн хөгжлийн сангаас олгох орлогын шилжүүлгээс, 1,582.1 сая төгрөгийн өмнөх оны үлдэгдлээс санхүүжүүлэхээр төлөвлөжээ.

➤ Сумдын сум хөгжүүлэх сангийн зарлагын төлөвлөгөө буюу эргэн төлөгдөх зээлд 2,439.8 сая төгрөгийг олгохоор төлөвлөсний 662.3 сая төгрөгийг өмнөх оны үлдэгдлээс, 1,777.5 сая төгрөгийг үйл ажиллагааны орлогоос санхүүжүүлэхээр сумдын ИТХ-аар баталжээ.

Төсвийн зарлагын гүйцэтгэлийн талаар:

Аймгийн ТЕЗ 2020 онд нийт 84,016.0 сая төгрөгийн зардал санхүүжүүлэхээр төлөвлөж 76,456.7 сая төгрөгийн зардалтай ажиллаж, төсвийг 7,559.3 сая төгрөгөөр хэмнэсэн байна.

Энэхүү хэмнэлт нь тайланд онд цар тахал Монгол улсад дэгдсэнтэй холбоотой ерөнхий боловсролын сургууль, хүүхдийн цэцэрлэгийн үйл ажиллагааг түр зогсоосны улмаас норматив зардал, үдийн цай, дотоод албан томилолт, цалин хөлс, нийгмийн даатгалын шимтгэл, бусад тэвчиж болох урсгал засвар, бусдаар гүйцэтгүүлсэн ажил үйлчилгээний төлбөр зэрэг зардлуудад хэмнэлт үүссэн, сум хөгжүүлэх сангийн зээлийг төлөвлөсөн хэмжээгээр олгоогүй зэрэгтэй холбоотой байна.

Нийт зардлын гүйцэтгэл

Хүснэгт 10 /сая.төг/

ЗАВХАН АЙМГИЙН ТЕЗ-ИЙН ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛД ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

д/д	Зардлын төрөл	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Хэмнэл/+/ хэтрэлт/-/	Элэх хувь
1	НИЙТ ЗАРДАЛ	84,016.0	76,456.7	7,559.3	100.0
2	УРСГАЛ ЗАРДАЛ	72,340.2	67,672.2	4,668.0	88.5
3	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	45,117.2	43,552.3	1,564.9	57.0
4	Ажил олгогчоос төлөх НДШ	6,123.8	5,728.5	395.3	7.5
5	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	7,842.9	7,495.3	347.6	9.8
6	Хангамж бараа материалын зардал	2,072.1	1,930.8	141.3	2.5
7	Норматив зардал	3,769.3	2,428.7	1,340.6	3.2
8	Эд хогшил урсгал засварын зардал	595.1	384.2	210.9	0.5
9	Томилолт зочны зардал	335.3	214.6	120.7	0.3
10	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил үйлчилгээний төлбөр хураамж	2,934.2	2,599.3	334.9	3.4
11	Бараа үйлчилгээний бусад зардал	3,550.3	3,338.5	211.8	4.4
	ТАТААС	13.8	13.8	0.0	0.0
12	Хувийн хэвшлийн байгууллагад өгөх татаас	13.8	13.8	0.0	0.0
	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	1,488.6	1,200.8	287.8	1.6
13	Бусад урсгал шилжүүлэг буюу тэтгэмж урамшуулал	1,488.6	1,200.8	287.8	1.6
14	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	10,173.4	7,569.9	2,603.5	9.9
15	Бусад хөрөнгө	7,733.6	6,179.3	1,554.3	8.1
16	Эргэж төлөгдөх зээл	2,439.8	1,390.6	1,049.2	1.8



Төсвийн зарлагын гүйцэтгэлийг салбар бүрээр нь авч үзвэл:

✓ Орон нутгийн зарлагын төсвийн гүйцэтгэл:

ЗАВХАН АЙМГИЙН ТЕЗ-ИЙН ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛД ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Орон нутгийн төсвийн санхүүжилтээр нийт 33,115.3 сая төгрөгийн зардлыг санхүүжүүлэхээр төлөвлөж 31,047.7 сая төгрөгийн зардлыг санхүүжүүлж орон нутгийн төсвийг 2,067.6 сая төгрөгөөр хэмнэсэн байна. Энэ нь орон нутгийн байгууллагуудын тээвэр шатахуун, урсгал засвар, албан томилолт зэрэг зардлуудад хэмнэлт үүссэнтэй холбоотой бөгөөд уг хэмнэлт нь бодит биш, цар тахлын нөхцөл байдалтай холбоотой бий болсон байна. Мөн сум хөгжүүлэх хөгжүүлэх сангаас олгох зээлийг төлөвлөсөн хэмжээгээр олгоогүй нь нөлөөлжээ.

Орон нутгийн төсөвт байгууллагууд нь тайлант оны эцэст зарцуулаагүй үлдэгдэл 446.3 сая төгрөгийг орон нутгийн төсөвт төвлөрүүлжээ.

Төсөвт байгууллагуудын зарцуулаагүй үлдэгдлийг төвлөрүүлэхдээ тухайн санхүүжилтийн эх үүсвэртэй нь уялдуулан төвлөрүүлэх нь зүйтэй байна гэж үзлээ. Учир нь орон нутгийн төсөвт байгууллагууд нь аймгийн төсвөөс олгох санхүүгийн дэмжлэгээс санхүүждэг бөгөөд зарцуулаагүй үлдэгдлийг буцаан төвлөрүүлэхдээ сумын төсөвт төвлөрүүлж байна. Төсвийн тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.7 “Энэ хуулийн 43 дугаар зүйлд зааснаас бусад тохиолдолд төсвийн жил дуусахад төсвийн захирагчийн төсөв зарцуулах эрх нь дуусгавар болох бөгөөд төсвийн захирагчийн төсвийн зарцуулагдаагүй үлдэгдлийг тухайн шатны төсвийн ерөнхий дансанд татан төвлөрүүлнэ” гэж заасан нь тухайн хэмнэгдсэн төсвийг эх үүсвэрээс нь үл хамааран тухайн шатны төсөвт төвлөрүүлэх зохицуулалттай байгаа боловч ийнхүү сумын төсөвт төвлөрүүлэх нь сумын хөрөнгийн үлдэгдэл өсөж эргэлт удаашрах, хөрөнгө зориулалт бус зарцуулагдах эрсдэлийг бий болгож байна.

Төрийн сангийн үйл ажиллагааны журмын 6.2 “ Улсын төсвийн болон орон нутгийн төсвийн орлогыг төсөвт төвлөрүүлэх үйл ажиллагааг төсвийн байгууллага хариуцан гүйцэтгэнэ” гэж заасан бөгөөд төсөвт байгууллагуудад тухайн санхүүжилтийн эх үүсвэрт тулгуурлан төвлөрүүлэх талаар чиглэл хүргүүлж ажиллах нь зүйтэй гэж үзлээ.

Төсөвт байгууллагуудын санхүүжилтийг батлагдсан төлөвлөгөөний хүрээнд олгосон эсэхийг хянаж үзэхэд төсөвт байгууллагуудын төлөвлөгөөнд холбогдох эрх бүхий албан тушаалтны шийдвэргүй зохицуулалт хийсэн байна. Тухайлбал:

1. Сумдын ИТХ-ын төсөв хооронд 3.5 сая төгрөгийг гүйлгэн зарцуулах, 12.6 сая төгрөгийг нэмж олгох зохицуулалт хийж, 4 сумын ИТХ-ын төсөвт 14.8 сая төгрөгийг нэмж олгосон /Завханмандал ИТХ 3.5 сая, Цагаанхайрхан 4.0 сая, Тосонцэнгэл ИТХ 6.0 сая/

2. Сумдын ЗДТГ-ын төсөв хооронд 19.2 сая төгрөгийг гүйлгэн зарцуулах зохицуулалт хийсэн ч уг төсвийг олгоогүй бөгөөд, 2 сумын ЗДТГ-т 2.1 сая төгрөгийн илүү санхүүжилт олгосон

3. Соёлын төвүүдийн төсөв хооронд 33.7 сая төгрөгийг гүйлгэн зарцуулах, 17.1 сая төгрөгийг нэмж олгох зохицуулалт хийж, 4 сумын соёлын төвд 34.7 сая төгрөгийн илүү санхүүжилт олгосон байна. /Сантмаргаз соёлын төв 33.5 сая/

4. ТЕЗ-ийн тайланд нэгтгэгддэг орон нутгийн бусад төсөвт байгууллагуудын төсөвт зохицуулалт хийж 3 байгууллагад 32.3 сая төгрөгийн санхүүжилт илүү олгосон /Байгаль орчны газар 27.3 сая, Хөгжимт жүжгийн театр 4.5 сая төгрөг/ зэрэг зөрчлүүдийг давтан гаргахгүй байх албан шаардлага хүргүүлэхээр шийдвэрлэлээ.

✓ Тусгай зориулалтын шилжүүлгийн зарлагын төсвийн гүйцэтгэл:

Тусгай зориулалтын шилжүүлгийн байгууллагууд нь тайлант онд 45,969.0 сая төгрөгийн зардал санхүүжүүлэхээр төлөвлөж 42,431.1 сая төгрөгийн зардалтай ажилласан нь төсвийг 3,537.9 сая төгрөгөөр хэмнэсэн байна.

Тусгай зориулалтын шилжүүлгийн байгууллагуудын санхүүжилт олголт болон зарцуулалтыг хянан үзэхэд байгууллагуудын төсвийг гүйлгэн зарцуулсан, илүү санхүүжилт олгосон зэрэг зөрчил байна. Тухайлбал:

1. Сургуулийн өмнөх боловсролын байгууллагуудын санхүүжилт баталсан төсвөөс 434.0 сая төгрөг дутуу олгосон хэдий ч 6 сумын хүүхдийн цэцэрлэгт 71.4 сая төгрөгийн санхүүжилт илүү олгосон /Алдархаан сумын хүүхдийн цэцэрлэг 23.2 сая, Баянтэс сумын хүүхдийн цэцэрлэг 36.1 сая, Баянхайрхан хүүхдийн цэцэрлэг 1.8, Түдэвтэй сумын хүүхдийн цэцэрлэг 3.0 сая, Цагаанхайрхан хүүхдийн цэцэрлэг 6.0 сая, Асгат хүүхдийн цэцэрлэг 1.4 сая/

2. Ерөнхий боловсролын сургуулийн санхүүжилт 687.7 сая төгрөг дутуу олгосон боловч 6 сумын сургуульд 110.2 сая төгрөгийн санхүүжилт илүү олгосон /Алдархаан ЕБС 67.9 сая, Идэр ЕБС 13.9 сая, Нөмрөг ЕБС 7.0 сая, Улиастай 4-р сургууль 2.0 сая, Цагаанхайрхан ЕБС 12.7 сая, Цагаанчулуут ЕБС 6.5 сая/

3. Эрүүл мэндийн төвүүдийн санхүүжилтийг батлагдсан төсвөөс 58.4 сая төгрөг дутуу олгосон хэдий ч 4 сумын эрүүл мэндийн төвд 55.6 сая төгрөгийн санхүүжилт илүү олгосон / Алдархаан сумын ЭМТ 41.4 сая, Дөрвөлжин сумын ЭМТ 1.0 сая, Тэс сумын ЭМТ 7.0 сая, Цэцэн-Уул сумын ЭМТ 6.0 сая/ зэрэг зөрчлийг давтан гаргахгүй байх албан шаардлага хүргүүлэхээр шийдвэрлэлээ.

Тусгай зориулалтын шилжүүлгийн төсвөөс тайланд онд хоол хүнс, үдийн цай хөтөлбөрийн хэмнэлт, оны эцэст зарцуулагдаагүй үлдэгдэл 3,537.9 сая төгрөгийг улсын төсөвт төвлөрүүлжээ.

Аймгийн засаг даргын 2020 оны А/111, А/408 дугаар захирамжуудаар шинэ коронавирусын халдвараас урьдчилан сэргийлэх ажлын хүрээнд сумдын болон аймгийн төвийн хяналтын цэг, постод ажиллаж байгаа ажилчдыг хоол ундаар хангахыг аймгийн Боловсрол. соёл урлагийн газар болон ерөнхий боловсролын сургуулийн захирал, хүүхдийн цэцэрлэгийн эрхлэгч нарт үүрэг болгосны дагуу тус байгууллагууд хоолны зардлаас 65.2 төгрөгийг уг арга хэмжээнд зарцуулжээ.

Үүнээс гадна орон нутгийн төсөвт байгууллагууд ковид цар тахалтай холбоотой нийт 328.2 сая төгрөгийн зардал гаргажээ

✓ Орон нутгийн хөгжлийн сангийн зарлагын гүйцэтгэл:

Аймгийн орон нутгийн хөгжлийн санд олгох орлогын шилжүүлгээс 4,276.8 сая төгрөгийн санхүүжилт орж ирсний 1,403.0 сая төгрөгийг сумдын ОНХС-д, орон нутгийн суурь зарлагад 171.1 сая төгрөг, аймгийн ОНХС-д 2,702.4 сая төгрөгийг олгожээ.

Сумдын ОНХС-д 1,403.0 сая төгрөгийн санхүүжилт олгосон нь батлагдсан төсвөөс 90.5 сая төгрөг дутуу байна. Энэ нь ОНХС-ийн санхүүжилт аймагт дутуу орж ирсэнтэй холбоотой 4 суманд 89.5 сая төгрөгийн санхүүжилтийг дутуу олгосон байна.

✓ Сум хөгжүүлэх сангийн зарлагын гүйцэтгэл:

СХС-ийн зээлийн эргэн төлөлтөд 1,390.7 сая төгрөгийн зээл олгосон нь батлагдсан төсвийн 57 хувь байна. Сум хөгжүүлэх зээлийн зээлийн эргэн төлөлт удаашралтай, гэрээний хугацаанд эргэн төлөлтийг бүрэн барагдуулдаггүй, хугацаа хэтэрсэн зээлийн үлдэгдэл өндөр байгаа зэрэгтэй холбоотой зарим сум тайлант онд сум хөгжүүлэх зээлийг олгоогүй байна. Сум хөгжүүлэх сангийн авлагын үлдэгдэл 5,505.3 сая төгрөг байна. Үүнээс зээлийн эргэн төлөлт хангалтгүй, хугацаа хэтэрсэн зээлийн их хэмжээний үлдэгдэлтэй, зээлийг төлүүлэх арга хэмжээ авч ажиллаагүй, хууль хяналтын байгууллагад зээлийн эргэн төлөлтийн хугацаа хэтэрсэн иргэдийг шилжүүлээгүй Завханмандал, Түдэвтэй, Тэс сумдад албан шаардлага хүргүүлсэн.

ЗОРИЛТ 3. НЭМЭЛТ САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО, ЗАРДАЛ

Нэмэлт санхүүжилтийн дансаар нийт 4,080.8 сая төгрөгийн орлого төвлөрч 3,734.2 сая төгрөгийг урсгал зардалд 277,1 сая төгрөгийг хөрөнгийн зардалд зарцуулж, 68.7 сая төгрөгийг улсын төсөвт төвлөрүүлж 328.6 сая төгрөгийн зарцуулаагүй үлдэгдэлтэй байна.

Нэмэлт санхүүжилтийн орлого

д/д	Орлогын төрөл	Хүснэгт 12 /сая.төг/	
		Өмнөх он	Тайлант он
1	Төрийн болон орон нутгийн өмчит бус этгээдээс авсан хандив	384.5	21.8
2	ЗГНХ, ЗДНХ, түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	0.0	28.9
3	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	1,254.8	1,292.6
4	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	948.7	2,737.5
	ДҮН	2,588.0	4,080.8

ЗОРИЛТ 4. АВЛАГА, ӨГЛӨГАвлага:

ТЕЗ-ийн санхүүгийн тайланд нийт 6,061.5 сая төгрөгийн авлага тусгагдсан нь өмнөх оны үлдэгдлээс 0.6 сая төгрөгөөр өссөн байна.

Авлагын үлдэгдэл

ЗАВХАН АЙМГИЙН ТЕЗ-ИЙН ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛД ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Хүснэгт 13 /сая.төг /

д/д	Байгууллагын нэр	2019	2020	Өсөлт/-/ бууралт/+
1	Сум хөгжүүлэх сан	5,491.5	5,505.3	-13.8
2	Эрүүл мэндийн төв	34.5	29.0	5.5
3	Хүүхдийн цэцэрлэг	13.1	30.6	-17.5
4	Ерөнхий боловсролын сургууль	80.4	49.6	30.8
5	ЗДТГ	67.6	42.8	24.8
6	ИТХ	14.0	5.7	8.3
7	Соёлын төв	2.4	3.4	-1.0
8	ОНӨААТҮГ	109.9	151.4	-41.5
9	Бусад төсөвт байгууллагууд	51.0	47.2	3.8
10	Аймаг хөгжүүлэх сан	41.5	41.5	0.0
11	Төрийн сан	153.7	153.7	0.0
12	Аймгийн ОНХС	1.3	1.3	0.0
	ДҮН	6,060.9	6,061.5	-0.6

Авлагын дүнд төсвийн шууд захирагч нартай холбоотой 208.3 сая төгрөгийн авлага бүртгэгдсэн нь өмнөх онтой харьцуулахад 54.7 сая төгрөгөөр буурсан боловч, байгууллага тус бүрээр хянахад тайланд онд 66.5 сая төгрөгийн авлага шинээр үүссэн байна.

Төсвийн шууд захирагчдын санхүүгийн аудитаар хэмнэгдсэн зардлыг харилцагч байгууллагад шилжүүлэн авлага үүсгэсэн 12.2 сая төгрөгийн зөрчилд төлбөрийн акт тогтоосон байна.

Өглөг:

ТЕЗ-ийн тайланд 840.0 сая төгрөгийн өглөг тусгагдсан нь өмнөх оны үлдэгдлээс 62.3 сая төгрөгөөр буурсан байна.

Богино хугацаат өр төлбөрийн үлдэгдэл

Хүснэгт 14 /сая.төг/

д/д	Байгууллагын нэр	2019	2020	Өсөлт /-/ бууралт /+ /
1	Сумдын орон нутгийн хөгжлийн сан	24.5	42.9	-18.4
2	Эрүүл мэндийн төв	16.1	34.4	-18.3
3	Хүүхдийн цэцэрлэг	16.8	3.9	12.9
4	Ерөнхий боловсролын сургууль	76.3	92.5	-16.2
5	ЗДТГ	9.5	36.2	-26.7
6	ИТХ	2.5	11.5	-9.0
7	Соёлын төв	67.4	35.1	32.3
8	ОНӨААТҮГ	559.3	479.9	79.4
9	Бусад төсөвт байгууллагууд	40.5	14.3	26.2
10	Төрийн сан	41.6	41.6	0.0
11	Аймгийн ОНХС	47.8	47.8	0.0
	ДҮН	902.3	840.1	62.2

ТЕЗ-ийн тайланд тусгагдсан богино хугацаат өр төлбөрийн дүнд төсвийн шууд захирагч нарын үйл ажиллагаатай холбоотой 227.9 сая төгрөгийн өглөг бүртгэгдсэн нь өмнөх онтой харьцуулахад 1.2 сая төгрөгөөр буурсан байна. Гэвч тайлант онд 171.7 сая төгрөгийн өглөг шинээр үүсжээ.

Төсвийн шууд захирагчдын санхүүгийн тайланд авлага, өглөг үүссэн нь төсвийн шууд захирагч нар хэмнэгдсэн зардлыг төсөвт төвлөрүүлэлгүй харилцагч байгууллагад шилжүүлэн авлага үүсгэдэг, албан хаагчдын ажлын хариуцлагагүй байдал, ажилчдад олгосон цалингийн урьдчилгааг тухай бүр суутган тооцдоггүй, он дамжуулдаг, төсвийн төлөвлөлт бодитой бус зэрэгтэй холбоотой байна гэж үзлээ.

Төсвийн шууд захирагчид тайланд онд авлага, өглөг үүсгэж байгаа нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.8 “төсвийг зохистой удирдаж авлага, өр төлбөр үүсгэхгүй байх”, 39 дүгээр зүйлийн 39.4.2 “өр, авлага үүсгэхгүй байх”, гэсэн заалтуудтай нийцэхгүй байна. Иймд цаашид төсвийн шууд захирагчдын төсөвт авлага, өглөг үүсгэхгүй байх, тайланд тусгагдсан авлагыг барагдуулах, он дамжуулахгүй байх шаардлагатай байна.

ДҮГНЭЛТ:

- ✓ Төсөвт байгууллагуудын зарлагын төлөвлөгөөг батлахдаа байр ашиглалттай холбоотой тогтмол зардлаас гүйлгэн зарцуулахаар баталсан нь төсвийн хөрөнгө үрэлгэн, зориулалт бус зарцуулагдах эрсдэлтэй гэж үзэж байна.
- ✓ Төсөвт байгууллагуудад санхүүжилт нэмж хуваарилсан нь Төсвийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 11.1.16 “төсвийн ерөнхийлөн захирагч, төсвийн байгууллага, бусад этгээдэд улсын төсвөөс санхүүжүүлэх хөтөлбөрийн санхүүжилтийг батлагдсан төсвийн дагуу олгох” гэсэн заалттай нийцэхгүй байна.
- ✓ Өмнөх оны ТЕЗ-ийн төсвийн гүйцэтгэлд дүгнэлт өгөх аудитын тогтмол зардлаас бусад төсөвт байгууллагуудад нэмэлт төсөв хуваарилахгүй байх талаар тусгаж, чиглэл хүргүүлсэн боловч хэрэгжүүлж ажиллаагүй байна.
- ✓ Сумдад санхүүжилт олгохдоо батлагдсан төсвийн хуваарийн дагуу олгоогүй байна.
- ✓ Төсөвт байгууллагуудын төлөвлөгөөнд холбогдох эрх бүхий албан тушаалтны шийдвэргүй зохицуулалт хийсэн байна.
- ✓ Тусгай зориулалтын шилжүүлгийн байгууллагуудын санхүүжилт олголт болон зарцуулалтыг хянан үзэхэд байгууллагуудын төсвийг гүйлгэн зарцуулсан, илүү санхүүжилт олгосон зэрэг зөрчил байна
- ✓ Төсвийн шууд захирагчид тайлант онд авлага, өглөг үүсгэж байгаа нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.8 “төсвийг зохистой удирдаж авлага, өр төлбөр үүсгэхгүй байх”, 39 дүгээр зүйлийн 39.4.2 “өр, авлага үүсгэхгүй байх”, гэсэн заалтуудтай нийцэхгүй байна.

ЗӨВЛӨМЖ

АЙМГИЙН ЗАСАГ ДАРГА Д.ТҮВШИНЖАРГАЛ ТАНАА

Төсвийн ерөнхийлөн захирагчийн санхүүгийн тайлангийн аудитаар илэрсэн алдаа зөрчилд үндэслэн дараах зөвлөмжийг хүргүүлж байна.

1. Аймгийн Иргэдийн төлөөлөгчдийн хурлаар баталсан төсвийн хуваарийг баримталж ажиллах
2. Төсвийн ерөнхийлөн захирагч төсвийг хуваарилахдаа зардал хооронд гүйлгэн зарцуулахгүй байх, сангийн яамнаас баталсан төсөвт байгууллагуудын зардлын хэмжээг баримтлах
3. Төсөвт байгууллагуудад илүү, нэмэлт санхүүжилт олгох, хуваарилахгүй, төсвийг гүйлгэн зарцуулахгүй байх
4. Төсвийн шууд захирагчдын санхүүгийн үйл ажиллагаанд үүссэн авлага, өглөгт дүн шинжилгээ хийж, төсвийг зохистой удирдах
5. Төсвийн хуваарийг сумдад тухай бүр хүргүүлэн, мөрдөж ажиллах

Аудитаар өгсөн зөвлөмжийг хэрэгжүүлэн ажиллаж, биелэлтийг Завхан аймаг дахь Төрийн аудитын газарт 2021 оны 9 сарын 25-ны дотор ирүүлэх

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР

Д.БАТ-УНДРАА